

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ¹ 19 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 14.30 цагт эхэлж, 15.50 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 20 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалуудад тус тус томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргах тухай	1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Пунцагдоржийн Ганхуягийг томилуулахаар санал, дүгнэлт гарган дэвшүүлж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Гантулгад санал болгох, 2.Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Батсүхийн Бямбажавыг томилуулахаар санал, дүгнэлт гарган нэр дэвшүүлж Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол тус тус гаргав.
2	Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны референтээр ажиллаж байсан Г.Чагнаадоржийн гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	“Ажилд томилох тухай” Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 12 дугаар захирамжийн “Нэг”-ийн “64”-т “Гаваагийн Чагнаадоржийг мөн хэсэгт референт-судлаачаар” гэснийг болон “Г.Чагнаадоржийг ажлаас халах тухай” мөн даргын 2009 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 160 дугаар захирамжийг бүхэлд нь тус тус хүчингүй болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав.
3	Тагнуулын ерөнхий газарт ажилтан асан В.Нямханд, С.Энхтайван, Р.Азбаяр нарын ажлаас үндэслэлгүй халагдсан тухай гаргасан гомдлыг шалгасан Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Хойшлуулав.
4	Улсын Их Хурлын Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны шинжээчийн албан тушаалд нэр дэвшигч Г.Нургүлийн ажилд томилуулахыг хүссэн гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн Тухай	Хойшлуулав.
5	Бусад асуудал: Төрийн жинхэнэ албан тушаалд ажиллуулах тухай	1/Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Дотоод асуудал, хүний нөөцийн асуудал хариуцсан референтийн албан тушаалд Н.Туяаг, 2/мөн Тамгын газрын Шагналын асуудал хариуцсан ахлах шинжээчийн албан тушаалд Б.Хонгорзулыг,

		<p>3/мөн Тамгын газрын Иргэдийн өргөдөл, гомдол, захидал харилцааны асуудал хариуцсан референтийн албан тушаалд Д.Түвшинтулга, Л.Очирсүрэн нарыг,</p> <p>4/Мөн Тамгын газрын Бичиг хэрэг, редакцийн асуудал хариуцсан ахлах зааварлагчийн албан тушаалд А.Баттунгалаг нарыг уг албан тушаалуудад тус тус томилуулахаар томилох эрх бүхий этгээдэд нь санал болгохоор тогтов.</p> <p>Харин тус Тамгын газрын Хуулийн асуудал хариуцсан албан тушаалд Ч.Мөнхбатыг уг албан тушаалд тавигдсан шаардлагыг хангаагүй гэж үзэж Зөвлөлийн гишүүд 100 хувь дэмжээгүй.</p>
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
